



**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.06.05 № 122 ВАСАН/2013/СТА-ЗГОНТ

**Авлага шийдвэрлүүлэх тухай**

Засгийн газрын 2012 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар Анод банк татан буугдсанаас шалтгаалан Засгийн газрын бондын эх үүсвэрээс санхүүжүүлэн "40000 орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд уг банкаар дамжуулан иргэдэд олгосон орон сууцны зээлийн авлага 1,560,284,141.50 төгрөгийг ямар байгууллага хариуцаж барагдуулах нь тодорхойгүй, тооцоо нийлж актаар баталгаажуулаагүй зөрчил дутагдал илэрлээ.

Энэ нь Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-д: "санхүү, төсвийг зохистой удирдаж, авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д: "санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1.12-т: "аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх...", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2009 оны 47 дугаар тушаалаар батлагдсан "төлбөрийн акт тавих албан шаардлага өгөхөд баримтлах журам"-ын 3.1.1-д ".....алдаа зөрчлийг арилгуулахаар төрийн аудитын байгууллага холбогдох албан тушаалтанд албан шаардлага өгнө" гэж заасныг тус тус үндэслэн доорх албан шаардлагыг өгч байна.

1. Засгийн газрын бондын эх үүсвэрээс санхүүжүүлэн "40000 орон сууц хөтөлбөр"-ийн хүрээнд Анод банкаар дамжуулан иргэдэд олгосон орон сууцны зээлийн авлага барагдуулах байгууллагыг тодорхой болгох, авлагыг тооцоо нийлж актаар баталгаажуулах арга хэмжээг авч ажиллах
2. Албан шаардлагаар өгсөн үүргийн биелэлтийг 2013 оны 10 дугаар сарын 1-ний дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Ц.Ариунсанаа нарт даалгаж байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
АУДИТОР

И.ТУЯА

